



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ИРГЭН Д.ЭНХТАЙВАН:

"Оюу Толгой компани 2013 онд манай сумыг байнгын эрчим хүчтэй холбосон. Ингэснээр Ханбогд сумын айл, албан байгууллага болгонд ач тусгаа өгч байна. Эрчим хүчтэй болсноор манай гэр бүлийнхэн талх, нарийн боовны үйлдвэрлэл явуулж эхэлсэн"



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ИРГЭН М.ЗОРИГОО:

"Цахилгаантай болсноор хүмүүсийн аж амьдралд их ахиц дэвшил гарсан. Телевизээ үзэж, интернэт хэрэглэж, бүхий л мэдээлээ авч байна. Сумын гэрэлтүүлэг их сайхан боллоо. Хүмүүс хөргөгч, цахилгаан зуух гээд бүх төрлийн цахилгаан хэрэгсэлээ ашиглаж байна"



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ИРГЭН Ц.МӨНХЧУЛУУН:

"Цахилгаантай болсноос хойш гал түлэхээ байсан. Цахилгаанаар ажилладаг дулааны халаалттай боллоо. Өмнө нь 12 цагаас хойш хүн төрөхөд лаа бариад хэцүү байлаа. Арай боломжтой бол бензин авч, мотор асаадаг байсан. Хувь хүний эдийн засгийн хувьд хамгийн өргөн хэрэгцээ цахилгаан байдаг учир Галбачуудын амьдрал ахуйд ихээхэн түлхэц өгсөн байх гэж боддог"



ХАНБОГД СУМ, АНИР ХУР ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ХУЯГ:

"Цахилгааны хязгаарлалттай байхад хугацаанд нь ажлаа амжуулах шаардлага гарна. Ажил ихтэй үед зардал чиргэдэл болгож, жижиг оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байсан. Одоо байнгын, найдвартай цахилгаантай болсноор бүх ажил хугацаандаа явагдаж байна"

